

ЯПОН ДАХЬ МОНГОЛЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ СУРВАЛЖ БИЧИГ СУДАЛГААНЫ ТУХАЙД

Т. Мөнхцэцэг (МУИС)

Дэлхийн олон улс оронд монгол орныг сонирхон судладаг билээ. Монгол судлал хөгжсөн орны нэг нь Япон юм. Тус өгүүлэлд Япон монголын түүхэнд холбогдох сурвалж бичгийг хэдий үеэс эхлэн орчуулж, судалж ирсэн, энэхүү судалгааны чиглэл хандлагын талаар товч авч үзье.

Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгийг нягтлан судлах талаар японы монгол судлаач эрдэмтэд их зүйлийг хийсэн бөгөөд тэрхүү судалгаа нь олон жилийн түүхэн уламжлалтай. Монголын түүхэн сурвалжийг судлагч тэдгээр эрдэмтэд нь монголын түүхийн гол гол сурвалж бичгүүдийг орчуулга, галиг, тайлбарын хамт хэвлүүлсэн нь япон дахь монгол судлалын үндсийг тавьж өгчээ.

Анх 1907 онд XIII зууны үеийн монголын түүхийн гол сурвалжийн нэг «Монголын нууц товчоо»-г дорно дахины нэрт судлаач, Нака Мичиёо «Чингис хааны үнэн тэмдэглэл» (Чингис хан жицүраку) нэртэйгээр орчуулан тайлбарын хамт гаргасан нь япон дахь монголын түүхэн сурвалж бичиг судлах эх үндсийг тавьсан төдийгүй монгол судлал үүсэн хөгжих хөрс нь болж өгсөн байна. Түүний судалгаа нь монголын сурвалж бичгийг судлахад хойч үеийн судлаачдыг уриалан дагуулснаараа чухал ач холбогдолтой юм. Хойч үеийн судлаачид нь ч доктор Нака Мичиёогийн «Монголын нууц товчоо»-ны орчуулга, тайлбарыг өнөө хүртэл эрдэм шинжилгээний ач холбогдоллоо алдаагүй бүтээл хэмээн онцлон тэмдэглэдэг. Тухайлбал профессор Ш. Озава Доктор Нака Мичиёогийн «Чингис хааны үнэн тэмдэглэл» нь «Монголын нууц товчоо»-г гадаадад орчуулж, тайлбар хийсэн анхны бүтээл, мөнхийн гэрэлт бүтээл юм хэмээн үнэлсэн бол доктор М. Мураками Нака Мичиёогийн орчуулга тайлбар нь сонгодог бүтээл юм гэжээ.

Үүний дараахи «Монголын нууц товчоо»-ны талаархи судалгаанд Кобаяши Такаширогийн орчуулга², Ширатори Куракичигийн галиг хадмал орчуулгаз томоохон байр эзлэх юм. Чухамхүү энэ үеэс «Монголын нууц товчоо»-г хэл, түүх, уран зохиолын талаас нь судлах болсон байна. Профессор Хаттори Широ «Монголын нууц товчоо»-г хэлний талаас нь анх нарийвчлан судалжээ. Тэрээр «Монголын нууц товчоог монгол хэлээр илэрхийлж буй ханз үсгийн судалгаа зохиолдоо монгол үгийг ханз үсгээр хэрхэн тэмдэглэсэн талаар нарийвчлан авч үзсэн бөгөөд өнөө хир энэ хэмжээнд хийсэн судалгаа гараагүй байна. «Монголын нууц товчоо»-г хэлний талаас нь судлахын зэрэгцээ Ширатори Куракичи, Кобаяши Такаширо, Ивамура Шинобу, Мураками Масацүгү зэрэг олон судлаачид түүхийн талаас нь авч үзэх болсон бөгөөд үүнд монголчуудын гарал үүсэлтэй холбоотой домог, газар усны нэр, хүний нэр, болсон үйл явдлуудыг тайлбарласан нь нэлээд сонирхолтой болжээ. Т. Кобаяшигийн «Монголын нууц товчооны судлал» ном нь сурвалж бичиг судалгааны үүднээс хийсэн ховор бүтээлийн нэг билээ.

дорвитой бүтээлийн дотор доктор М. Мураками, профессор Сүүлийн үеийн «Монголын нууц товчоо»-ны судалгааны Ш. Озавагийн судалгаа зүй ёсоор орох юм. Доктор М. Мураками «Монголын нууц товчоо»-г орчуулан тайлбар сэлтийн хамт 1970-аад онд гурван боть болгон хэвлүүлсэн байна. М. Мураками «Монголын нууц товчоо»-г дахин орчуулж тайлбар хийх болсон тухайгаа Нака Миchieогийн орчуулга, тайлбар Мэйжигийн сүүл үед (1907) гарсан тул өнөөгийн уншигчдад сйгомжтой буулгах үүднээс, мөн сүүлийн үеийн «Монголын нууц товчоо»-ны талаар гарсан үлэмж судалгаанд түшиглэн тайлбар хийх болсон гэжээ. М. Мураками «Монголын нууц товчоо»-г сурвалж болох үүднээс нь түүний ач холбогдлыг үнэлэхдээ XII—XIII зууны үеийн монгол тухайлбал монгол үндэстнийг нэгтгэсэн Чингис хааны үйл амьдралыг голлон монголын эзэн улсын үүслийг өгүүлсэн түүхэн зохиол болно гэж тэмдэглэсэн байна. Тэрээр тайлбар хийхдээ өөрийн орны болон гадаадын эрдэмтдийн «Монголын нууц товчоо»-ны талаар болон XII, XIII зууны үеийн монголын түүхээр гарсан сүүлийн үеийн судалгааны материалд үндэслэсэн нь түүний судалгааг улам далайцтай болгожээ.

Профессор Ш. Озава 1980-аад онд «Монголын нууц товчоо»-г хэлний талаас нь нарийвчлан судалж тайлбар хийн 6 боть ном болгон гаргажээ⁸. Ш. Озава тайлбартаа үгийн үүсэл гарлыг нэг бүрчлэн нарийн авч үзсэн нь дундад зууны үеийн монгол хэлийг судлахад чухал бүтээл болсон байна.

Монголын түүх судалдаг японы эрдэмтэн, судлаач нар монголын төрийн зохион байгуулалт, нийгмийн анги давхрааны ялгарал, эдийн засаг, соёл, шашин шүтлэг, зан заншлын талаар судалгаа хийхдээ «Монголын нууц товчоо»-г түүхэн сурвалжийнх нь хувьд өндөр үнэлж гол тулгуур сурвалж болгон ашигласаар иржээ. Судлаач Т. Кацубүши «Монголын нууц товчоо нь монгол үндэстний үүслээс авахуулаад Чингис, Өгөөдэй хааны түүхийг өгүүлсэн хамгийн гол үндсэн сурвалж болно. «Юан улсын судар» ч перс хэлээр бичигдсэн «Судрын чуулган» ч угтаа Монголын нууц товчооноос эхтэй»⁹ гэсэн байна. Гэвч зарим судлаачид тус сурвалжийг домог, уран зохиолын шинжтэй, түүхэн сурвалж болохынх нь хувьд учир дутагдалтай гэж үздгийг тэмдэглэх хэрэгтэй.

Монголын түүхэн сурвалж тэр дундаа «Монголын нууц товчоо»-г судлаач японы эрдэмтдийн судалгаа нь энэхүү сурвалжийг судлаач дэлхийн олон орны эрдэмтдийн судалгаанд чухал байр суурь эзэлдэг юм.

«Монголын нууц товчоо»-ны судалгааны зэрэгцээ монголын түүхийн холбогдолтой хэд хэдэн чухал сурвалж бичгийг орчуулан гаргажээ. Үүнд «Алтан товч»-ийн судалгаа орох юм. Проф. Ямамото Маморү «Хураангуй алтан товч»-ийг «Чингис хааны үгийн бичиг» нэртэйгээр анх орчуулж «Тооёо ши кэнкюү» (Дорно дахины түүхийн судлал) сэтгүүлд цуврал маягаар нийтлүүлсэн боловч бүрэн нийтлэгдээгүй байна. Харин проф. Кобаяши Такаширо «Алтан товч»-ийн бүрэн орчуулгыг 1939 онд «Алтан товч-монголын он цагийн тэмдэглэл» нэртэйгээр нийтлүүлсэн ба үүнийгээ дахин засварлан 1941 онд —Монголын алтан түүх-монгол үндэстний сурвалж» нэртэйгээр хэвлүүлжээ¹⁰.

«Монголын нууц товчоо», «Алтан товч»-ийн орчуулгаас

гадна Ямамото Мамору нь Саган Сэцэний «Эрдэнийн товч»-ийг судалж «Маншюү шигаку» сэтгүүлд хэвлүүлсэн бөгөөд проф. Го Минору уг сурвалжийг манж хэлнээс орчуулан тайлбар сэлтийн хамт 1940 онд хэвлүүлсэн байна.

Аливаа улс орны нийгмийн харилцааг нарийвчлан судлахад тухайн үеийн хууль цаазны бичиг чухал сурвалж хэрэглэгдэхүүн болдог билээ. Тиймээс ч нүүдэлчдийн нийгмийн харилцааны онцлог, түүнийг хуулиар хэрхэн зохицуулж байсан болон алба татварын систем, феодал ангийн онцгой эрх дарх зэрэг олон зүйлийг нарийвчлан тодруулахад чухал мэдээ агуулсан монголын хууль цаазын бичиг тухайлбал 1640 оны Монгол Ойрадын «Их цааз», «Халх журам»² зэргийг орчуулсны зэрэгцээ энэхүү хууль цаазыг судалж чухал бүтээлүүд туурвижээ. Мөн XVI—XVII зууны үеийн хууль цаазны бичиг «Халхын шинэ олдсон хууль эрхэмжийн дурсгалт бичиг»-ийг Фүтаки Хироши «Үйсэн дээрхи хууль» нэртэйгээр хэсэгчлэн орчуулж тайлбарын хамт хэвлүүлсэн байна³.

Тэрчлэн хаадуудын намтар, үйл ажиллагааг судлан, орчуулж тайлбарын хамт хэвлүүлсэн нь судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж байна. Тухайлбал, Т. Морижавагийн Түмдийн Алтан ханы намтар, Ж. Миявакигийн Ойрадын Зая Бандидын намтар зэргийг дурдаж болно.

Дээр өгүүлсэн монголын түүхэнд холбогдох сурвалж бичгийн судалгааны зэрэгцээ манж, хятад, төвд зэрэг бусад хэлнээс монголын түүхэнд холбогдох материалыг орчуулж, эмхтгэн гаргасан байна. Тухайлбал монголын эртний улсуудын талаар хятад сурвалж дахь материалыг эмхтгэн, орчуулж «Морьтон үндэстний түүх» нэртэйгээр 3 боть болгон гаргажээ. I ботид Үчида Гэнпү, Кавачи Ёшихиро, Мори Масао, Тамура Жицүзо, Канда Нобүо нар Хүннү, Ухань, Сяньби, Жужан, Шивэй, Кидан, Үжи, Мө Жэгийн талаар «Түүхэн тчмдэглэл» (Ши зи), «Хан улсын бичиг» (Хань шү), «Хожуу Хан улсын бичиг» (Хоу Хань шү), «Вэй улсын бичиг» (Вэй шү), «Сүн улсын бичиг» (Сүн шү), «Өмнөд Ци улсын бичиг» (Нань Чи шү), «Лянь улсын бичиг» (Лянь шү), «Хуучин Тан улсын бичиг» (Жю Тан шү), «Шин Тан улсын бичиг» (Шинь Тан шү) зэргээс авч орчуулан, тайлбар хийсэн бөгөөд он цагийн хэлхээсийг Оосава Тэрүмичи хийжээ⁴. II ботид Тэлэ, Түрэг, Баруун Түрэг, Уйгартай холбоотой хэсгийг Сагучи Тоорү, Ямада Нобүо, Мори Масао нар «Шинэ Тан улсын бичиг», «Хуучин Тан улсын бичиг», «Жоу улсын бичиг» (Жоу шү), «Сүй улсын бичиг» (Сүй шү)-ээс түүвэрлэн авч орчуулан, тайлбар хийсэн байна⁵. Ш ботид Татаар, Ойрад, Урайнхайн тухай «Мингийн түүх» (Мин ши); «Хуучин Тан улсын бичиг», «Шинэ Тан улсын бичиг»-ээс холбогдох хэсгийг авч орчуулан, тайлбар хийжээ⁶. Ийнхүү монголын нутаг дэвсгэр дээр төр улсаа байгуулж явсан нүүдэлчдийн улсын түүхэнд холбогдох хэсгийг хятад хэлээр бичигдсэн 13 сурвалжаас түүвэрлэн авч орчуулан тайлбар хийсний дээр он цагийн хэлхээс, газрын зургийг хавсаргажээ. «Морьтон үндэстний түүх» 3 боть зохиол нь эртний улсуудын түүхийг нарийвчлан судлахад чухал хэрэглэгдэхүүн болсон байна.

Японд буй Хубилай хааны довтолгоонтой холбогдсон хамгийн эртний материал нь 1293 оны «Монголын довтолгооны

зурагт ном» болно. Тус зурагт номыг 2 удаагийн довтолгоонд биеэр оролцож явсан Такэзаки Сүэнага нар өөрсдөө тулалдаанд хэрхэн байлдаж байсныгаа дүрслэн үзүүлэх үүднээс хүнээр зуруулсан бөгөөд 2 дэвтэрээс бүрдэнэ. Нэгдүгээр дэвтэр нь 23 метр гаруй, Хоёрдугаар дэвтэр нь ойролцоогоор 20 метр урт юм. Энэхүү номыг Камакурагийн үеийн зургаар илэрхийлсэн үнэн тэмдэглэл ч гэж үздэг. «Монголын довтолгооны зурагт ном»-оос тухайн үеийн Юаны цэргүүдийн хэрэглэж байсан зэр зэвсэг болон хөлөг онгоцны дүр төрх, байлдааны арга барил, хувцас хэрэглэл зэрэг олон зүйлийг тодруулахад чухал сурвалж болно. Энэ сурвалж японы Кикүжи сүмд (Шинто шашны) одоог хүртэл бүрэн хадгалагдаж буй.

Дундад үеийн түүхээр «Мин Ши» (Мингийн түүх)-ээс монголын түүхтэй холбогдох хэсгийг түүвэрлэн 10 боть болгон 1943—1957 онуудад хэвлүүлсэн байна.

Манжийн үеийн монголын түүхэнд холбогдох материалыг манж хэлнээс япон хэлнээ орчуулан гаргажээ. Тухайлбал Х. Окада, Н. Канда, Мацумура нар манжийн хаадын түүхийг орчуулсан бөгөөд энэхүү материалд Манж Чин улсаас Монголын талаар явуулж байсан бодлогын талаар нилээдгүй тусгагдсан байдаг. Профессор Х. Окада 1696, 1697 онд Манж Чин улсын хаан Энх—Амгалан өөрийн биеэр цэрэг удирдан Галдан хааныг дайлж үедээ хүүдээ бичиж байсан захидлуудыг манж хэлнээс япон хэлнээ орчуулж, судлагааны хамт «Энх—Амгалан хааны захидал» нэртэйгээр хэвлүүлэн гаргажээ. Эдгээр захидлууд нь Энх—Амгалан хааны Галданы талаар баримтлаж байсан бодлого, Галданы цэрэгтэй хэзээ, хаана, хэрхэн байлдсан, байлдааны үйл явц, тухайн үеийн Халхын ноёдын бодол санаа зэргийг тодруулахад чухал материал юм.

Тэрчлэн ХШ зууны үед монголд ирсэн Плано Карпини, Марко Поло нарын замын тэмдэглэлийг орчуулжээ. Ийнхүү монгол болон бусад хэлний сурвалжийг олноор орчуулан гаргасан нь японы монгол судлаачдад судалгаагаа явуулах өргөн боломжийг нээж өгсөн байна.

Японы монгол судлаачид монгол, манж, төвд, хятад болон бусад хэлээр бичигдсэн монголын түүхтэй холбоотой сурвалж бичгийн материалыг эх хэлнээ орчуулсан төдийгүй түүнийг галиглах, эрдэм шинжилгээний тайлбар хийж мөн сурвалж судлалын үүднээс авч үзсэн нь япон дахь монгол судлалын нэг чиглэлийг бий болгожээ. Сурвалж бичиг судлал японд хөгжих болсон гол үндэс нь түүнийг суурь судалгаа гэж үзэн судалгаагаа хийх болсон явдал юм.

Японы монголын түүх бичлэг дэх үндсэн чиглэлийн нэг болох сурвалж бичгийн судалгаанаас харахад холбогдох сурвалжийг орчуулан түүнийгээ нягтлан тайлбарлах хандлага зонхилж байгаа бөгөөд энэ нь нэг талаар Япон дахь монголын түүх судлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, түүхийн бүхий л үеийг хамарсан хандлагатай болоход зохих нөлөө үзүүлсэн байна. Тэгээд ч монголын эрт, дунд үеийн түүхийн талаар японы түүх судлаачдын туурвисан олон арван нэгэн сэдэвт зохиол, өгүүлүүд гарчээ.

Ашигласан ном зохиол

1. Нака Мичиёо. Чингис хааны үнэн тэмдэглэл (Чингис кан жицүроку). 1907. Дай нихон тошё.
2. Кобаяши Такаширо. Монголын нууц түүх (Мооко—но хиши). 1941. Токио. Сэйкацүшя.
3. Ширатори Куракичи. Галигчилсан Монголын нууц товчоо (Оняку мообүн гэнчёо хиши). 1943. Тооёо бунко.
4. Хаттори Широ. Монголын нууц товчоог хятад үсгээр илэрхийлж буй нь түүний судалгаа, Рюүмон шёкёкү, 1946.
5. Кобаяши Такаширо. Монголын нууц товчооны судлал (Мооко гэнчёо хиши кэнкюү).
6. Озава Шигэо. Монголын нууц товчоо (Гэнчёо хиши), Иванами шётэн, 1994, 243-р тал.
7. Мураками Масацүгү. Монголын нууц түүх (Монгорү хиши), I боть 1970, II боть 1972, III боть 1976, Хэйбоншя.
8. Озава Шигэо. Монголын нууц товчооны бүрэн тайлбар (Гэнчёо хиши—но зэншяку) Токио, 1984.
9. Кацүбүши Такэши. Хөх чоно, Чингис хаан (Аоки ооками, Чингис кан), Монголын эзэнт улс, Дэлхийн түүх цуврал 12, Сэкай бункашя, 1973, 97-р тал.
10. Кобаяши Такаширо. Монголын алтан түүх—монгол үндэстний сурвалж бичиг (Мооко ооганши—мооко минзоку—но котэн). 1941. Сэйкацүшя. Токио.
11. Го Минорү. Эрдэнийн товч (Мооко гэнрюү). 1940. Токио.
12. Таяма Шигэрү. Монголын хууль цаазын судалгаа (Мооко хоотэн—но кэнкюү). Гакүжюцү кёокай, Токио. 1967.
13. Фүтаки Хироши. Үйсэн хуулийн орчуулга тайлбар (Якүцюү ширакаба хоотэн). I. Юүбокү шякай ши танкюү, сэтгүүл №50, 1977, II. Монгол судлал сэтгүүл №12, 1981. Ш. Монгол судлал сэтгүүл. №14, 1983.
14. Морьтон үндэстний түүх (Киба минзоку ши). I боть, 1971, Хэйбоншя
15. Морьтон үндэстний түүх (Киба минзоку ши). II боть, 1972, Хэйбоншя
16. Морьтон үндэстний түүх (Киба минзоку ши). III боть, 1973. Хэйбоншя
17. Окада Хидэхиро. Энх-Ампалан хааны захидал (Кооки тэй—но тэгами), Чюү оо коороншя, 1979.